



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 11 (392)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГГИЙН ЗАРЛИГ

- Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
- Зарим хүмүүсийг шүүгчийн албага тушаалд томилох тухай

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗВЫН ТОГТООЛ

- Сүлжмэл эдлэл өөмөлбүтээгдээгүй үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын Тамгын Газар

Улаанбаатар хот

2005 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны гуравдугаар сарын 21

№11 (392)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

617.	Бүгд Найрамдах Австри Улсын иргэн Бригитте Винклзэнэрийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 22	210
618.	Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 23	210
619.	А. Оюуныг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 24	212
620.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилх тухай	Дугаар 25	212

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

621.	Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 32	212
622.	Дүрэм, журам батлах тухай	Дугаар 34	213
623.	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (Үргэлжлэл)	Дугаар 245	221

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

624.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 2/01	246
------	--	-------------	-----



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 3 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

### Бүгд Найрамдах Австри Улсын иргэн Бригитте Винклээнэрийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын боловсролын салбарын харилцаа, их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Австри Улсын Зальцбург хотын Их

сургуулийн профессор, хатагтай Бригитте Винклээнэрийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 3 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

### Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. "Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах

тухай" 2001 оны 25 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт, "Зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай" 2001 оны 91 дүгээр зарлиг, "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2004 оны 29 дүгээр зарлигийн нэг дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 23 дугаар зарлигийн хавсралт*

### МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	-Хууль зүй, дотоод хэргийн сайд
Орлогч дарга:	-Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
Нарийн бичгийн дарга:	-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга
Гишүүд:	-Улсын дээд шүүхийн эрүүгийн танхимын тэргүүн шүүгч -Улсын ерөнхий прокурорын орлогч -Ерөнхий аудиторын орлогч -Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга -Бятлан хамгаалахын дэд сайд -Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд

- Зам, тээвэр, аялал жуулчлалын дэд сайд
- Сангийн дэд сайд
- Үйлдвэр, худалдааны дэд сайд
- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
- Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд
- Эрүүл мэндийн дэд сайд
- Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Тагнуулын ерөнхий газрын дарга
- Цагдаагийн ерөнхий газрын дарга
- Хил хамгаалах ерөнхий газрын дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга
- Улсын гаалийн ерөнхий газрын дарга
- Үндэсний татварын ерөнхий газрын дарга
- Онц байдлын ерөнхий газрын дарга
- Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга
- Стандартчилал, хэмжилзүйн төвийн дарга
- Оюуны өмчийн газрын дарга
- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга
- Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга
- Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга
- Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийн захирал
- Монголын ахмадын холбооны дарга
- Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч
- Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах монголын Нийгэмлэгийн тэргүүн
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн тэргүүн



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 3 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

### А. Оюуныг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Авирмэдийн Оюуныг Нийслэлийн Баянзүрх

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 3 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1 дүгээр шүүхийн шүүгчийн, Цэвэгдоржийн Баасанбаярыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Одонгийн Баатарсүхийг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Доржийн Сарангэрэлийг Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

Ганбаатарын Мягмарсүрэнг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Лхүндэвийн Наранбаяр, Хашхүүгийн Одбаяр нарыг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Зоригоогийн Нандинцэцэгийг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Намжилсүрэнгийн Оюунтуяа, Юндэнгийн Энхмаа нарыг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Пүрэвийн Баярмагнайг Ховд аймаг дахь сум дундын

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

### Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

олгож байхыг Сангийн сайд Н.Алтанхуягт зөвшөөрсүгэй.

Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчдоос төлсөн нийгмийн даатгалын төлбөрийн 50 хүртэл хувийг 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2006 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг харгалзан ажил олгогчдод улсын төсвийн хуваарилалдаагүй зардлаас нөхөн

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 3 дугаар сарын 2-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

### Дүрэм, журам батлах тухай

Шуудангийн тухай хуулийн 6.1.2, 6.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрмийг 1 дүгээр хавсралт, Шуудангийн илгээмжийг түр хадгалах, задлах, хураах болон

устгах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Г.БАТХҮҮ**

*Засгийн газрын 2005 оны 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт*

### ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД МӨРДӨХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь Шуудангийн тухай хуулийг хэрэгжүүлэх, шуудангийн үйлчилгээ, технологи, үйл ажиллагааг зохион байгуулах, шуудангийн үндсэн сүлжээг эзэмшигч, түрээслэгч болон өөрийн сүлжээ бүхий шуудангийн үйлчлэгчид болон үйлчлүүлэгчдийн (иргэн, аж ахуйн нэгж, байгууллага) хоорондын харилцааг зохицуулна.

1.2. Улс хоорондын шуудангийн үйлчилгээтэй холбогдсон харилцааг Монгол Улсын олон улсын гэрээнд энэ дүрэмд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

Хоёр. Шуудангийн үйлчилгээ

2.1. Шуудангийн үндсэн үйлчилгээнд энэхүү дүрмийн хүрээнд зохицуулагдах шуудангийн илгээмжийг хүлээн авах, дамжуулах, гардуулах үйл ажиллагаа, шуудангийн марк, үнэт цаасны эх зураг зохион хэвлүүлж, гадаад, дотоодын зах зээл дээр борлуулах, шуудангийн хайрцаг ажиллуулах, тогтмол хэвлэлийн захиалга хүлээн авах, хүргэхээс гадна Шуудангийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан болон Дэлхийн шуудан холбооны конвенци бусад олон улсын гэрээгээр зөвшөөрөгдсөн үйлчилгээ хамаарагдана.

2.2. Шуудангийн тухай хуулийн 4.1-д заасан үйлчлэгч нь хуульд заасан журмын дагуу дараахь нэмэгдэл үйлчилгээ үзүүлж болно:

2.2.1. шуудангийн илгээмжийн хаяг, мэдэгдэл, бланк маягтуудыг бичих, илгээлт, боодлыг боож, савлах (хайрцаглах), илгээлтийн хайрцаг, уут, боодлын цаас бэлтгэж борлуулах;

2.2.2. цахилгаан холбооны зарим үйлчилгээг гэрээний дагуу үзүүлэх (телефон яриа, электрон үйлчилгээ гэх мэт);

2.2.3. илгээмжийн худалдаа (үйлчлүүлэгчийн захиалгаар өргөн хэрэглээний барааг хаягт эзэнд нь хүргэж гардуулах үйлчилгээ);

2.2.4. төрөл бүрийн акц, хонжворт сугалаа, ном товхимол, календарь, тэмдэглэлийн дэвтэр борлуулах;

2.2.5. зарим төрлийн мэдээллийн лавлагааг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргэх;

2.2.6. шуудангийн маршрут, чиглэлийн дагуу автомашины даацанд тохируулан зорчигч тээвэрлэх;

2.2.7. шуудангийн илгээмжийн гардуулалтын лавлагааг тогтоосон хугацаанаас өмнө хийж, үйлчлүүлэгчид мэдэгдэх;

2.2.8. улс хоорондын шуудангийн хариултын купоны үйлчилгээ.

2.3. Шуудангийн үйлчилгээний төрөл, зориулалт, түүнийг үйлчлүүлэгчид хүргэхтэй холбогдсон харилцаа нь Шуудангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10, 11, 12, 13, 14 дүгээр зүйлүүдээр зохицуулагдана.

2.4. Шуудангийн үйлчилгээний хамрах хүрээг үйлчлэгчийн санал, холбогдох судалгааг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хавсралт гэрээгээр тогтооно.

2.5. Шуудангийн үйлчилгээнд Шуудангийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хугацааг



баримтлах бөгөөд үйлчлэгч өөрийн сүлжээний дамжуулах чадвар, үйлчилгээний хамрах хүрэнээс хамааруулан өөрийн хугацааг хуульд зааснаас цөөн хоногоор тогтоож болно;

2.6. Үйлчлэгч нь хугацаагаа үйлчлүүлэгчид ил тод байлгах бөгөөд сүлжээ эзэмшигч үйлчлэгч нь бусад үйлчлэгчидтэй харилцан холболтын гэрээг ижил нөхцөлөөр байгуулж, өөрийн хугацаагаа баримтална.

2.7. Үйлчлүүлэгч нь гадаад улс орноос манай улсад оршин суугчийн хаягаар захидал явуулахдаа хүлээн авагчаас илгээх хариу захидлын төлбөрийг хийхэд нь зориулан энгийн захидлын агаарын тарифтай тэнцэх шуудангийн маркаар солигдох боломжтой төлбөрийн хэрэгсэл болох улс хоорондын шуудангийн хариултын купоныг захидлын хамт илгээж болно.

2.8. Улс хоорондын шуудангийн хариултын купоныг мөнгөөр солихыг хориглох бөгөөд хэрэв купон нь хуурамч, хүчингүй нь тогтоогдвол үйлчлэгч хүлээн авахаас татгалзах эрхтэй.

2.9. Нэг явуулагчаас нэг буюу хэд хэдэн хүлээн авагчид олон тооны илгээлтийг нэг удаагийн явуулалтаар илгээх групп илгээлтийг Consingment буюу бөөн илгээлт гэж нэрлэх бөгөөд улс хоорондын бөөн илгээлтийн үйлчилгээг хоёр улсын хооронд гэрээ байгуулсны үндсэн дээр явуулна.

Энэхүү үйлчилгээнд тусгай таних тэмдэг хэрэглэнэ. Consingment-гэдэг үгийг цэнхэр өнгөөр дунд нь бичиж, 3 тууш зураасыг улаан, цэнхэр, ногоон өнгөөр 2 талд ялган зурж дор дурдсан байдлаар үйлдэнэ:

Consingment

Грав. Шуудангийн илгээмж

3.1. Үйлчлүүлэгчдийн Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор солилцож байгаа шуудангийн илгээмжийг дотоод шуудангийн илгээмж гэнэ.

3.2. Дэлхийн бусад орноос Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хаягт эзэндээ хүргэгдэж байгаа, мөн Монгол Улсаас дэлхийн бусад улсуудад хүргэгдэж байгаа шуудангийн илгээмжийг улс хоорондын шуудангийн илгээмж гэнэ.

3.3. Шуудангийн үндсэн үйлчилгээгээр Шуудангийн тухай хуулийн 3.1.4, 3.1.5, 3.1.6 болон 19-р зүйлд хамаарагдах дараахь илгээмжүүдийг хүлээн өгч, дамжуулан гэрдуулна. Үүнд:

3.3.1. битүүмжилсэн захидал (энгийн, баталгаатай, үнэ зарласан);

3.3.2. ил захидал (энгийн, баталгаатай);

3.3.3. боодол (энгийн, баталгаатай, үнэ зарласан);

3.3.4. илгээлт (энгийн, үнэ зарласан).

3.4. Бүх төрлийн баталгаатай, үнэ зарласан шуудангийн илгээмж нь бүртгэгдсэн илгээмжид хамаарагдана.

3.5. Шуудангийн тухай хуулийн 20.3-т заасан шуурхай зэрэглэлийн шуудангийн илгээмжид "Express" гэсэн тусгай таних тэмдэг бүхий дугтуй, хайрцаг сав хэрэглэж болох бөгөөд хэрэв энгийн дугтуй, хайрцаг, сав ашигласан тохиолдолд үйлчлэгч тэдгээрийн зүүн дээд өнцөгт эсхүл явуулагчийн хаягийн дор тавигдах "Express" гэсэн бичлэг бүхий дардас хэрэглэнэ.

3.6. "Express" шуудангийн илгээмжийг гардуулахдаа үнэ зарласан шуудангийн илгээмжийн нэг адил мэдэгдэл бичиж хаягт эзэнд нь хүргэх бөгөөд нэг удаагийн шуурхай хүргэлтээр хаягт эзэн нь олдоогүй тохиолдолд дараагийн удаа уг илгээмжийг ердийн шуудангийн илгээмжийн нэгэн адил төхологиор хүргэж, гардуулна.

3.7. Үйлчлэгч express шуудангийн илгээмжийг эхний ээлжинд боловсруулж (ялгах, гаалийн үзлэгт хамруулах зэрэг) хамгийн дөт, шуурхай чиглэл, маршрутаар явуулна.

3.8. Шуудангаар үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр явуулах илгээмжийг Дэлхийн шуудан холбооны дүрэм, конвенци болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйлчлэгч тогтооно.

3.9. Дотоод шуудангаар дараахь илгээмжүүдийг үнэ төлбөргүй явуулна:

3.9.1. хараагүй хүмүүст зориулсан товгор үсгээр бичсэн ном хэвлэл, мөн секограммын аргаар бичсэн захидлынхаа дээд өнцөгт "Секограмм" (секограммаас зөвхөн агаарын тээврийн зардлыг тооцсон төлбөр авч болно) гэсэн таних тэмдэг бүхий ил захидлууд;

3.9.2. шуудангаар үйлчлэгчид өөрийн харьяа газруудын хооронд солилцож байгаа албаны илгээмжүүд.

3.10. Улс хоорондын шуудангаар дараахь илгээмжүүдийг үнэ төлбөргүй явуулна:

3.10.1. Дэлхийн шуудан холбооны байгууллагын гишүүн орнуудын шуудангийн захиргаа болон Олон улсын товчоотой солилцож байгаа илгээмжийн дээд буланд "албаны" буюу "SERVISE DES POSTES" гэсэн дардас бүхий захидал, шуудангийн илгээмжийн төрлүүд;

3.10.2. цэргийн олзлогсдын төв лавлах агент буюу үндэсний лавлах товчооны явуулж байгаа болон ирүүлж байгаа нүүрэн талын дээд буланд "Service des internes" гэсэн тэмдэг бүхий бичиг захидлууд.

Дөрөв. Шуудангийн технологи ажиллагаа

4.1. Дотоод шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, дамжуулах, гардуулах ажиллагаа нь дотоод шуудангийн үйлчилгээний стандартын дагуу явагдана.

4.2. Улс хоорондын шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, гардуулах ажиллагаа нь улс хоорондын шуудангийн үйлчилгээний стандартын дагуу явагдана.

4.3. "Улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн бүрдүүлэлт хийх журам"-ыг шуудангийн болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар баталж мөрдөнө.

Тав. Шуудангийн үйл ажиллагаанд хориглох зүйлүүд

5.1. Шуудангийн тухай хуулийн 24.1-д зааснаас гадна дараахь зүйлүүдийг шуудангаар илгээхийг хориглоно:

5.1.1. битүүмжлэгдсэн захидал, боодол, илгээлтээр Монгол Улсын мөнгөн тэмдэгт, гадаад валют, үнэт эрдэнэсийн зүйлс;

5.1.2. битүүмжлэгдсэн захидал дотор хатуу, хурц иртэй зүйлүүд (хутганы ир, зүү, тэмдэг, хавчаар г.м.) болон ахуйн хэрэгцээний, мөн үйлдвэрлэлийн зориулалттай зүйлс;

5.1.3. илгээмжийг хүлээн авагчийн нэр төр, үндэсний зан заншилд харш болон шуудангийн бусад илгээмжүүдийг эвдэж, бохирдуулах зүйлс;

5.1.4. ариутгал хийгдээгүй хуучин гутал, хувцас, цагаан хэрэглэл;

5.1.5. боловсруулаагүй гэрэл зургийн хальс, гэрэл зургийн цаас зэрэг рентген туяагаар харж болохгүй зүйлс;

5.1.6. нэг төрлийн барааны олон тоогоор хэвлэсэн шошго.

5.2. Үнэ зарласан шуудангийн илгээмжээр бусад шуудангийн илгээмжид цагаан алт, алт, мөнгөн эдлэл буюу байгалийн байдлаараа байгаа эрдэнийн чулуу, бусад үнэт эдлэлүүд, банкны билет, кредит билет, аялалын чек зэрэг зүйлүүдийг хийж явуулахыг хориглоно.

5.3. Улс хоорондын шуудангийн илгээмжээр хувийн нууцад хамаарах зүйлсийг явуулагч болон хүлээн авагч нь гуравдагч этгээдээр дамжуулсан хаягаар солилцохыг хориглоно. Хэрэв үйлчлэгч түүнийг олж тогтоовол өөрийн орны хууль дүрмээр зохицуулна.

5.4. Хэвлэмэл зүйл болон секограмм нь марк, банкны баримт бичгүүд, үнэ бүхий баримт бичгүүдийг агуулж болохгүй.

5.5. Шуудангийн захидлаар зөгий, торгоны хорхой, бичил биетнүүд, хорхой, шавьж илгээхийг хориглоно.

Зургаа. Тусгай журмын дагуу шуудангаар илгээх зүйл

6.1. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр дараахь зүйлүүдийг шуудангаар илгээж болно:

6.1.1. газрын хөрс, ургамал, амьтны гаралтай түүхий эд;

6.1.2. бүх төрлийн ангийн үс, түүгээр хийсэн эдлэл, загасны үр, сантоник ба түүгээр хийсэн эдлэл, эртний эдлэл (урлаг, дурсгалын зүйл, ном ба дууны нот), байгалийн чулуулаг, хөрсний дээж;

6.1.3. ан, амьтны гаралтай түүхий эд;

6.1.4. үнэт цаас, Монгол Улсын мөнгөн тэмдэгт, гадаад валютыг улс хоорондын буухиа шуудангаар илгээж болно.

6.2. Түргэн муудах биологийн зүйл, радиоидэвхт бодисуудыг зөвхөн зориулалтын битүүмжилсэн саванд хоёр улсын, эсхүл хүлээн авах улсын зөвшөөрөлтэйгээр явуулна. Дээрх зүйлийг Дэлхийн шуудан холбооны байгууллагын конвенцийн заалт болон бусад адилтгах байгууллагын дүрэм, журмын дагуу бэлтгэж зөвхөн агаарын шуудангаар явуулна.

Долоо. Шуудангаар явуулсан илгээмжийн хүлээн авагч (хаягт эзэн)-ийг гэрчлэх баримтууд



7.1. Бүртгэгдсэн илгээмжийг хүлээн авагчийн иргэний үнэмлэх болон дараахь бусад бичиг баримтыг үндэслэн олгоно:

7.1.1. оюутан, сурагчдад тэднийг харьяалах сургуулийн захиргаанаас олгосон сурагчийн ба оюутны үнэмлэх;

7.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэдэд цагдаагийн байгууллагаас олгосон оршин суух зөвшөөрлийн үнэмлэх;

7.1.3. мөн тус улсад түр хугацаагаар оршин суугаа гадаадын иргэдэд тэдний үндэсний гадаад паспор.

7.2. Үйлчлүүлэгч өөрийн хаягаар ирсэн илгээмжийг өөр хүнээр байнга болон түр хугацаанд төлөөлүүлэн авахуулахаар тухайн хүнд итгэмжлэл бичгийг нотариатын байгууллагаар батлуулан олгож болно. Итгэмжлэлийг ганц хувь үйлдэх бөгөөд итгэмжлэлийг хэнд олгосон, ямар төрлийн илгээмжүүдийг хүлээн авч болох, мөн итгэмжлэл олгосон албан байгууллагын нэр ба албан тушаалтны овог, нэр, он, сар, өдөр зэргээс гадна итгэмжлэлийн хүчинтэй байх хугацааг үсгээр тодорхой бичсэн байна.

7.3. Хүлээн авагч нь эмнэлэг, сувиллын газар эмчлүүлэн сувилуулж байгаа, асрамжийн газар амьдардаг, цэргийн алба хааж байгаа, хорих газар хоригдож байгаа буюу тэдгээрийн дэргэд нотариатын байгууллага байхгүй тохиолдолд түүний итгэмжлэлийг тухайн эмнэлэг, цэрэг, цагдаа, хорих байгууллага болон орон нутгийн засаг захиргааны эрх бүхий албан тушаалтан гэрчилж болно.

7.4. Хэрэв аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж байгаа бол итгэмжлэл нь тухайн байгууллагын даргын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажсан байна.

7.5. Шуудангийн илгээмжийг хүлээн авах итгэмжлэл нь нэг удаагийн бөгөөд хоёр жилээс илүүгүй хугацаатай байна. Аж ахуйн нэгж, байгууллага нь итгэмжлэлийг солих бол тэр тухайгаа үйлчлэгчид албан бичгээр мэдэгдэнэ. Олгосон он, сар, өдрийг тэмдэглээгүй итгэмжлэлийг хүчингүйд тооцно.

7.6. Шуудан хүргэгчээр хүргүүлсэн баталгаатай ба үнэ зарласан илгээмжийг хүлээн авах аж ахуйн нэгж, байгууллага нь түүнийг хүлээх авах эрх бүхий ажилтанд итгэмжлэл олгоно. Итгэмжлэл нь шуудан хүлээн авагчид үлдэх бөгөөд

баталгаатай ба үнэлэгдсэн шуудангийн илгээмж хүлээн авах бүрт шуудан хүргэгчид үзүүлнэ.

7.7. Үйлчлэгчээс илгээмжүүдийг хүлээн авахдаа үзүүлсэн нэг удаагийн итгэмжлэлийг шуудангийн ажилтан хураан авна. Итгэмжлэл нь хүлээн авагчийн хувийн бичиг баримт (иргэний болон цэргийн үнэмлэх)-ын хамт хүчинтэйд тооцогдоно.

Найм. Шуудангийн илгээмжийн нөхөн төлбөр авах

8.1. Үнэ нь дутуу төлөгдсөн буюу огт төлөгдөөгүй, хүчингүй, эсхүл өөр төрлийн хүчингүй марктай захидлыг буцах хаягаар нь буцаах бөгөөд явуулагчийн хаяг тодорхойгүй байвал хүлээн авагчаас шуудангийн илгээмжийн тарифын дутууг нөхөн төлүүлэхээр явуулна.

8.2. Үйлчлүүлэгч үнэ нь төлөгдөөгүй буюу дутуу төлөгдсөн захидал шуудангийн хайрцагт хийсэн байвал "төлбөр дутуу" гэсэн тэмдэг дарж уг илгээмжийг явуулагчийн хаягаар буцааж, зохих төлбөрийг гүйцэд төлсний дараа "нөхөн төлөв" гэсэн тэмдэг дарж, шуудангаар явуулахаар хүлээн авна.

8.3. Үнэ нь төлөгдөөгүй буюу дутуу төлөгдсөн улс хоорондын шуудангийн илгээмжүүдийг хаягласан газарт нь явуулахгүй бөгөөд төлбөрийг нь бүрэн төлүүлэхээр буцаана. Үнэ нь төлөгдөөгүй, буцах хаяггүй, явуулагч нь олдхогүй илгээмжийг шуудангийн гардуулагдаагүй илгээмжийг хадгалах газарт шилжүүлнэ.

Ес. Гардуулалтын тухай хариу мэдэгдэх

9.1. Гардуулалтын тухай хариу мэдэгдэх нөхцөлтэй илгээмжүүдийг хүлээн авах, ялган боловсруулах, гардуулах ажлыг тухайн илгээмжийн төрөл тус бүрт нийцүүлэн гүйцэтгэхээс гадна шуудангийн ажилтан дор дурдсан нэмэлт шаардлагуудыг биелүүлнэ:

9.1.1. илгээмжийг гардуулсан тухай мэдэгдлийг үйлчлүүлэгч (явуулагч)-ийн хүсэлтийн дагуу шуудангаар буюу мэдээлэл, холбооны бусад хэрэгслээр зохих төлбөртэйгээр дамжуулна.

9.2. Гардуулалтын лавлагаа хийх шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, дамжуулах, хаягт эзэнд нь гардуулах ажиллагаа нь дотоод шуудангийн үйлчилгээний стандартын дагуу хийгдэнэ.

Арав. Шуудангийн илгээмжийн лавлагаа хийх

10.1. Илгээмжийн зэрэглэл, дотоод ба гадаад шуудангийн аль төрөл болохоос нь



хамааран, үйлчлэгч уг илгээмжийг хүлээн авсан өдрөөсөө хойш явуулсан баталгаатай илгээмжээ хэзээ, хэнд гардуулсан тухай болон хаана байгааг тогтоолгох тухай үйлчлүүлэгчийн лавлагааг дор дурдсан хугацааны дараа хүлээн авна:

10.1.1. дотоодын ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор ажлын 3 хоног, аймаг, хотын хооронд хуанлийн 8 хоног, бусад газарт хуанлийн 15 хоног;

10.1.2. дотоодын шуурхай /экспресс/ зэрэглэлийн илгээмжийг хотын дотор ажлын 2 хоногийн дараа, аймаг, хотын хооронд хуанлийн 6 хоног, бусад газарт хуанлийн 12 хоногийн дараа;

10.1.3. дотоодын буухиа зэрэглэлийн илгээмжийг хотын дотор ажлын 1 хоногийн дараа, бусад газарт хуваарьт шуудан очсоноос хойш 2 хоногийн дараа;

10.1.4. улс хоорондын бүх төрлийн баталгаатай илгээмжийг шууданд хүлээлгэн өгснөөс хойш 4 долоо хоногийн дараа, харин буухиа шуудангаар илгээсэн илгээмжүүдийн лавлагааг ажлын 5 хоногийн дараа.

10.2. Шуудангийн илгээмжийн талаархи үйлчлүүлэгчийн лавлагааг үйлчлэгч хүлээн авах эцсийн хугацаа нь дотоод илгээмжийг хүлээн авснаасаа хойш 18 сар, улс хоорондын илгээмжийг хүлээн авснаасаа хойш 12 сар байна.

10.3. Дээр дурдсан хугацаанд шуудангаар хийсэн лавлагаанд ямар нэгэн төлбөр хураамж авахгүй. Харин энэ зүйлд заасан хугацаанаас өмнө хийсэн лавлагаанд ашигласан мэдээлэл, холбооны үйлчилгээний хөлсийг тооцож авна.

10.4. Шуудангийн илгээмжийн гардуулалтын тухай лавлагааг хүлээн авсан үйлчлэгч лавлагааны хариуг дараагийн графикт шуудангаар лавлагч үйлчлэгчид ирүүлнэ. Хэрэв ямар нэгэн шалтгаан гарвал лавлагч үйлчлэгчид урьдчилан мэдэгдэнэ.

10.5. Үйлчлүүлэгч (явуулагч) илгээмжийн гардуулалтын тухай хариу мэдэгдэх картыг баталгаатай захидлын нэгэн адил гардуулах бөгөөд харин лавлагааны хариуг шуудан болон мэдээлэл, холбооны бусад хэрэгслээр мэдэгдэх үүргийг үйлчлэгч хүлээнэ.

10.6. Лавлагаа хийхдээ тухайн илгээмжийн талаар авах шаардлагатай мэдээллийг зориулалтын маягтын дагуу бичиж явуулна. Хөдөө орон нутгаас улс хоорондын шуудангийн лавлагааг дотоод шууданд хэрэглэгдэх маягтаар үйлчлэгчийн

төв байгууллагын лавлагаа хариуцсан ажилтанд явуулах бөгөөд түүнийг зориулалтын маягтанд хуулж тухайн улсад нь явуулна.

10.7. Улс хоорондын шууданд анхны лавлагааг явуулснаас хойш 2 сарын дотор хариуг нь үйлчлүүлэгч (явуулагч)-д өгнө.

10.8. Лавлагааны маягтыг шаардлагатай бол мэдэгдлийн маягттай хамт явуулж хүлээн авагчаас зохих тэмдэглэгээг хийлгэн үйлчлүүлэгч (явуулагч)-д хариу өгнө.

Арван нэг. Шуудангийн илгээмжийг буцаах

11.1. Үйлчлэгч хаягт эзэн нь хүлээн авахаас татгалзсанаас гадна дараахь шалтгаанаар гардуулагдаагүй илгээмжийг үйлчлүүлэгчийн хаягаар нь буцаана:

11.1.1. хадгалах хугацаа дууссан;

11.1.2. явуулагчаас буцааж авахаар өргөдөл, хүсэлт ирүүлсэн;

11.1.3. хаяг тодруулах алба, орон нутгийн засаг захиргаа, цагдаагийн болон холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас хаягт эзний оршин суугаа газрыг мэдэхгүй байгаа буюу олж тогтоох боломжгүй гэсэн тодорхойлолт гаргасан;

11.1.4. хаягт эзэн нь нас барсан;

11.1.5. "Шүүхийн" гэсэн тусгай тэмдэглэлтэй баталгаатай захидал үйлчлэгч хүлээн авснаас хойш 14 хоногийн хугацаанд хаягт эзэндээ гардуулагдаагүй;

11.1.6. хаягт эзний нэрийг огт бичээгүй, бичсэн боловч ойлгомжгүй, буруу ташаа бичсэн;

11.1.7. аж ахуйн нэгж, байгууллагын хаягаар ирсэн боловч тухайн байгууллага нь татан буугдсан, дампуурсан, эсхүл байршлаа өөрчилсөн тухай шуудангийн хаягийн хөдөлгөөнөө хийлгээгүй.

11.2. Үйлчлүүлэгч (явуулагч) илгээмжээ буцааж авахыг хүсч, дараахь тохиолдолд үйлчлэгчид өргөдөл гаргаж болох бөгөөд тухайн илгээмжийг буцааж авахтай холбогдсон төлбөрийг өөрөө хариуцна:

11.2.1. хаягт эзэнд нь гардуулахаас өмнө;

11.2.2. энэ дүрмийн 5.3-ыг зөрчсөн тохиолдолд холбогдох байгууллагууд нь хураан авахаас өмнө;

11.2.3. хүлээн авагч улсын хууль, дүрэм зөрчсөний улмаас тухайн улсын үйлчлэгч холбогдох үйл ажиллагаа явуулахаас өмнө.

11.3. Илгээмжийг буцаахаас өмнө хаягт эзнийх нь шуудангийн шинэчлэгдсэн хаяг нь тодорхой болж, үйлчлүүлэгч (явуулагч)-ээс уг илгээмжийг шинэ хаягаар нь хүргүүлэх тухай хүсэлтээ үйлчлэгчид гаргавал хүсэлтийг биелүүлнэ.

11.4. Шуудангийн илгээмжийг буцаахдаа дотоод шуудангийн болон улс хоорондын шуудангийн үйлчилгээний стандарт, Монгол Улсын олон улсын гэрээний холбогдох заалт, гэрээ хэлцлийг мөрдөнө.

11.5. "Өөрөө хүлээн авахаар" хаяглагдсан сонин, хэвлэлийг хадгалах хугацаа дууссаны дараа хаягдал түүхий эдэд шилжүүлэх бөгөөд харин сэтгүүл, түүний хавсралтуудын нэр, дугаар, үнийг дагалдах хуудсанд бичиж, хэвлэлийн худалдаанд шилжүүлнэ.

Арван хоёр. Гардуулах боломжгүй шуудангийн илгээмжүүдийг хадгалах

12.1. Дараахь шалтгаанаар хаягт эзэндээ олгогдоогүй шуудангийн илгээмжийг үйлчлэгч нь 1 сар хүртэл хугацаагаар хадгална:

12.1.1. тухайн шуудангийн илгээмжийн очих хаяг нь зөв боловч хаягт эзэн нь ямар нэг шалтгааны улмаас хүлээн авахгүй удсан;

12.1.2. шуудангийн хайрцагнаас гарсан огт хаяггүй буюу хаяг нь бүрэн бус, ойлгомжгүй, нөхөн төлбөр хийгдээгүйгээс үйлчлүүлэгчид нь буцаагаагүй;

12.1.3. давагдашгүй хүчин зүйлийн улмаас, мөн тээвэрлэлт, ялган боловсруулалтын явцад гэмтэж эвдэрснээс очих ба буцах хаягууд нь арилж, үйлчлүүлэгчид нь буцаан олгох бололцоогүй болсон;

12.1.4. хаягт эзэн нь хүлээн авахаас татгалзсан, эсхүл буцах хаяг нь тодорхойгүй.

12.2. Байнгын үйлчлүүлэгч албан томилолт, ээлжийн амралтаар гадагшаа явахдаа өөрийн хаяг бүхий шуудангийн илгээмжийг түр хугацаагаар хадгалуулахаар гаргасан хүсэлтийг үйлчлэгч хүлээн авч болох бөгөөд "Өөрөө хүлээн авахаар" хаяглагдсан сонин, сэтгүүлийн хадгалах хугацааг сунгаж болно.

12.3. Хөдөө аж ахуй, геологи хайгуул, ой, ан агнуур, зам засвар зэрэг ажлаар байнга оршин суугаг газраасаа удаан хугацаагаар яваа хүмүүст ирсэн бичиг, захидал, хэвлэлийг дээрх хүмүүсийг харьяалдаг аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт гаргасан хугацаагаар хадгалж болно.

12.4. Боломжит бүх арга хэмжээ авсан боловч гардуулагдаагүй илгээмжийг түүний гардуулагдаагүй шалтгааныг тодруулсан тайлбартайгаар эзэндээ олгогдоогүй шуудангийн илгээмжээр бүртгэнэ. Зайлшгүй шаардлагатай нөхцөлд орон нутгийн засаг захиргааны болон цагдаагийн байгууллага, хаяг тодруулах албаны тодорхойлолтыг тухайн илгээмжид бүрдүүлнэ.

12.5. Хаягт эзэндээ олгогдоогүйгээс хадгалах хугацаа нь дууссан илгээмжийг аймаг, хотын шуудангаар үйлчлэгч нь харьяа нэгжүүдээсээ цуглуулан авч, харьяалах төв байгууллагадаа явуулахдаа дараахь шаардлагыг хангасан байна:

12.5.1. захидлын дугтуй болон боодлын хайрцаг, савны гадаргуу дээр илгээлтийн хаягийн дагалдах хуудасны ар талд эзэндээ олгогдоогүй шуудангийн илгээмжид бүртгэсэн шалтгааныг тодорхой бичих бөгөөд энэхүү тайлбар тэмдэглэлийн үндэслэлийг тухайн үйлчлэгчийн эрх бүхий ажилтан шалгасны дараа гарын үсгээ зурж баталгаажуулан уг илгээмжийн хаяг бүхий тал дээр "Хадгалах газарт" гэсэн тэмдэглэгээг хийнэ;

12.5.2. илгээмжүүдийг бичиж хадгалах газарт шилжүүлэхдээ тэдгээрийн дотуур дагаварт дараахь бичилтийг хийнэ:

-энгийн илгээмжийн тоо, ширхэг;

-баталгаатай илгээмжийн өгөгдсөн дугаар ба хүлээн авах газрын нэр;

-нөхөн төлбөр авах илгээмжийн тоо, ширхэг, нөхөн төлбөрийн мөнгөн дүн;

-илгээлт, үнэлэгдсэн захидал, боодлын зураасан код, баталгааны дугаар болон дагавар, дагалдах бичиг баримтын дугаар, үнэлгээний үнийн дүн;

-өгөгдсөн дугаарыг тогтоох бололцоогүй, эвдэрч гэмтсэн ба хаяг нь арилсан илгээлтийн тоо, ширхэг, нэр төрөл, эсвэл байгаа шинж байдлыг нь бичиж эдийн тодорхойлолтыг хавсаргана.

12.6. Илгээмжийг хадгалах газарт шилжүүлсэн дагаврын дээд өнцөгт "Эзэндээ



олгогдоогүй” гэсэн тэмдэглэл хийн 3 хувь бичиж, тухайн үйлчлэгчийн эрх бүхий ажилтан шалгаж, гарын үсгээ зурж баталгаажуулна. Дагаврын хоёр хувийг илгээмжтэй хамт явуулах бөгөөд нэг нь илгээмжийг хүлээн авсан тухай тэмдэглэлтэйгээр буцаж ирэх хяналтын хувь, нөгөө нь үйлчлэгчийн төв байгууллагад үлдэж хадгалагдах хувь болно.

12.7. Илгээлт, үнэ зарласан захидал, боодлыг тэдгээрийн тоо, ширхгээс үл хамааран хадгалах газарт битүүмжлэн явуулах бөгөөд харин захидал, мөнгөн гуйвуулгын мэдэгдлийг тусгайлан боож явуулна. Эдгээр илгээмжийн хаягийн шошгон дээр “Эзэндээ олгогдоогүй” гэсэн тэмдэглэл хийнэ.

12.8. Хаягт эзэндээ олгогдоогүй шуудангийн бүртгэлтэй илгээмжийг хадгалах газарт шилжүүлсэн тухай тэмдэглэлийг шуудан хүргэлтийн дэвтэр, мэдэгдэх хуудас, мөн дагаварт зохих ёсоор бичиж үлдээнэ.

12.9. Хадгалах газарт байгаа шуудангийн илгээмж нь Шуудангийн тухай хуулийн 6.1.3-т заасан журмаар зохицуулагдана.

Арван гурав. Шуудангийн технологийн баримт бичгүүдийг хадгалах

13.1. Шуудангаар үйлчлэгч нь шуудангийн технологийн бичиг баримтыг шуудангийн технологи ажиллагаа, солилцооны төрөл, тоо хэмжээнээс хамааруулан дотооддоо баталсан журмын дагуу хадгална.

13.2. Шуудангийн технологийн баримт бичгийг хадгалах хугацаа, тэдгээрийг бүртгэж тооцох үйл ажиллагаа нь архивын тухай хууль тогтоомж, үйлчлэгчийн архивын дүрэм, зааврын шаардлагыг бүрэн хангасан байна.

13.3. Улс хоорондын шуудангийн технологийн бичиг, баримтыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хадгална.

Арван дөрөв. Шуудангийн илгээмжээр дамжиж байгаа харилцааны нууцлалт

14.1. Шуудангийн илгээмжээр битүүмжлэн явуулж байгаа аливаа мэдээлэл, эд зүйлс нь хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийн захидал харилцааны нууцад шууд болон шууд бусаар хамаарагдах бөгөөд холбогдох хуулиар зохицуулагдана.

14.2. Үйлчлэгч нь захидал харилцааны нууцыг хадгалах үүргийг үйлчлүүлэгчийн өмнө хүлээх бөгөөд шуудангийн илгээмжээр явуулахыг хориглосон зүйлийн талаар үйлчлүүлэгчид урьдчилан мэдээлэх, сануулах үүрэгтэй.

Арван тав. Шуудангийн илгээмжийн аюулгүй байдал

15.1. Үйлчлэгч нь хүлээн авсан шуудангийн илгээмжийн аюулгүй байдлыг хаягт эзэнд гардуулах хүртэл бүрэн хариуцна.

15.2. Шаардлагатай гэж үзвэл үйлчлэгч дотооддоо шуудангийн илгээмжийг хүлээн авах, солилцох дамжлагад түүний аюулгүй байдлыг задлахгүйгээр шалгах нөхцөлийг бүрдүүлэх ба тур хадгалах зориулалтын агуулахтай байна.

15.3. Шуудангийн илгээмжийг үйлчлүүлэгчээс хүлээн авсны дараахь технологи үйл ажиллагааны аль нэг дамжлагад хийгдсэн аюулгүй байдлын шалгалтаар түүнийг цааш нь дамжуулахад харшлах зүйл илэрвэл тухайн үйлчлэгчийн шуудангийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтан уг илгээмжийг тусгаарлан, түүнийг явуулагчид мэдэгдэн зохих тайлбар гаргуулж, эрх бүхий байгууллагаар нарийвчлан шалгуулах буюу буцааж авахыг шаардах бөгөөд эс зөвшөөрвөл удирдлагадаа танилцуулан тухайн зүйлийг аюулгүй болгох эрх, үүрэг бүхий байгууллагад шилжүүлнэ.

15.4. Шуудангийн илгээмжийг саатуулах, шалгах ажиллагааг зөвхөн холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хийнэ.

15.5. Үйлчлэгч дараахь тохиолдолд хуулийн байгууллагад мэдэгдэн холбогдох арга хэмжээ авахуулна:

15.5.1. шуудангийн марк болон олон улсын хариултын купоныг хуурамчаар үйлдсэн, хуулбарласан, засварласан;

15.5.2. ашиглагдсан маркийг дахин хэрэглэсэн, маржоулах машин болон шуудангийн бусад дэрдсүүдыг хуурамчаар үйлдсэн, өөр зориулалтаар ашигласан.

15.6. Шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, солилцох, байр талбай, зөөвөр, тээврийн хэрэгслийг технологийн болон техник, гал, усны аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар зохион байгуулж тоногдосон байна.

## ШУУДАНГИЙН ИЛГЭЭМЖИЙГ ТҮР ХАДГАЛАХ, ЗАДЛАХ, ХУРААХ БОЛОН УСТГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шуудангаар үйлчлэгчдийн захидал харилцааны мэдээллийн аюулгүй байдлыг ханган нууцыг хадгалах, үйлчлэгч, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хамгаалах, Шуудангийн тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журамд Шуудангийн тухай хуулийн 23.1-д зааснаас гадна гаалийн болон тээврийн байгууллагын аюулгүй байдлын шалгалтын явцад шуудангаар илгээхийг хориглосон зүйл агуулсан байж болзошгүй нь илэрсэн илгээж хамаарна.

1.3. Энэ журмыг шуудангаар үйлчлэгч, түүний харьяа салбар, нэгжүүд дагаж мөрдөнө.

1.4. Энэ журмын 1.2-т хамаарах Улс хоорондын шуудангийн илгээмжтэй холбогдох харилцааг Олон улсын болон хоёр улсын үйлчлэгч хоорондын гэрээнд өөрөөр заасан бол тэрхүү гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

Хоёр. Илгээмжийг түр хадгалах

2.1. Энэхүү журамд хамаарагдах илгээмжийг түр хадгалах зорилгоор Шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрмийн 12.5 дахь заалтын дагуу үйлчлэгчийн төв байгууллагын хадгалах газарт шилжүүлнэ.

2.2. Хадгалах газарт шилжиж ирсэн илгээмжийг анх хүлээн авсан өдрөөс хойш түүний хаягт эзнийг хайх, хаягийг дахин тодруулахад зарцуулсан хугацааг оролцуулан 3 сар хүртэл хугацаагаар хадгална.

2.3. Үйлчлэгчийн төв байгууллагын удирдлага хадгалалтын хугацаа нь дууссан илгээмжүүдийн жагсаалтыг холбогдох ажилтнаар гаргуулан нарийвчлан танилцаж, тэдгээрийг хаягт эзэнд нь, эсхүл явуулагчид нь хүргэх талаар Шуудангийн тухай хууль, холбогдох дүрэмд заасан боломжит бүх арга хэмжээг авсан эсэхийг нягтлан шалгасны үндсэн дээр уг илгээмжүүдийг задалж холбогдох арга хэмжээг авах комисс байгуулах тухай шийдвэр гаргана.

Гурав. Шуудангийн илгээмжийг задлах

3.1. Энэ журмын 2.2-т заасан хадгалалтын хугацаа нь дууссан илгээмжийг задалж, холбогдох арга хэмжээг авах үйл ажиллагааг комисс гүйцэтгэх бөгөөд комиссыг үйлчлэгч байгууллагын удирдлагын шийдвэрээр Шуудангийн тухай хуулийн 23.2.1 дэх заалтыг үндэслэн байгуулна.

3.2. Шаардлагатай гэж үзвэл комиссын бүрэлдэхүүнд холбогдох мэргэжлийн байгууллагын ажилтныг оруулж болох бөгөөд комиссын гишүүд нь задарсан илгээж болон түүнээс гарсан зүйлийн талаархи нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.

3.3. Комисс нь илгээмжийг задалсан үйл явцын талаар тэмдэглэл үйлдэж дараахь зүйлийг тусгана:

-илгээмжийн гадна байдлын талаархи тодорхойлолт;

-задлахын өмнөх хүндийн жин;

-илгээмжийг задлахад илэрсэн зүйлсийн нэр, төрөл, тоо, ширхэг, бүрдэл, хүндийн жинг үзүүлсэн жагсаалт;

-илгээмжийн сав, баглаа боодлын жинг нэг бүрчлэн бичнэ.

3.4. Комисс нь задалсан илгээмжээс гарсан зүйлсийн талаар Шуудангийн тухай хуулийн 23.2.3, 23.3, 23.4-т тус тус заасан арга хэмжээг 10 өдөрт багтаан авна.

3.5. Илгээмжийг задлахад гарсан, тусгай зориулалтын бус, тодорхой байгууллага, хүмүүст холбогдолгүй боловч хэрэгцээ хангахуйц бараа, бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу үйлчлэгчийн мэдэлд шилжүүлнэ.

Дөрөв. Илгээмжийг устгах

4.1. Илгээмжийг задлахад гарсан тусгай зориулалтын бус, тодорхой байгууллага, хүмүүст холбогдолгүй, ямар нэгэн хэрэгцээ, шаардлага хангахгүй зүйлийг устгаж, устгалын акт үйлдэн комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

4.2. Устгал хийх явцад комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ байлцах бөгөөд устгалыг хийсэн газар, арга, устгал бүрэн хийгдсэн талаар актад тодорхой тусгана.

Тав. Бусад

5.1. Үйлчлэгч нь энэхүү журмаар зохицуулагдах илгээж болон түүнийг задлахад гарсан зүйлийг нэг бүрчлэн бүртгэх маягуудыг баталж мөрдүүлнэ.

5.2. Шуудангаар үйлчлэгч болон шуудангийн ажилтнууд эзэндээ олгогдоогүй илгээж, түүнийг задлахад гарсан зүйлийг комиссын шийдвэргүйгээр албаны болон хувийн зориулалтаар ашиглахыг хориглоно.

2004 оны 4-р сарын 24-ийн өдөр /2004 оны 4-р сарын 24-ийн өдөр/

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ\*

№	Тайлбар	Хэрэгжүүлэх аргачлал	Хариуцагч	Төлөвлөгөөний жил	Төлөвлөгөөний үзүүлэлт
129	2.6.19	Албадлагын хөдөлмөрийг устгах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох конвенцид нэгдэн орх, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1. Албадлагын хөдөлмөрийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 29, Албадлагын хөдөлмөрийг устгах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 105 дугаар конвенцид нэгдэн орх асуудлыг шийдвэрлүүлнэ. 2. Хуурийн хөдөлмөрийн тэнцлүүг хэлбэрүүдийг илгэн тооцож, улмаар аригдах талаар дэд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	2005	Ц.Баярсайхан Ц.Мөнх-Оргил
130	2.6.20	Эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чөлөөт хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг үндэслэн аж ахуйн нэгжийн өрсөлцөгөө үндэсний мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчид бэлтгэх ажлыг эдийн засгийн төлөв гарган хэрэгжүүлнэ.	1. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр, төслийн хүрээнд эхэлсэн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг тогтоолуулж, энэ талаар олон нийтэд мэдээлэх ажлыг өргөжүүлнэ. 2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоон болон чанарын судалгаанд үндэслэн үндэсний мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын хэрэгцээний хэтийн төлөвийг тооцно. 3. Барилгын салбарын мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчид бэлтгэх тусгай хөтөлбөрийг холбогдох намдтай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.	2004 оноос 2006 оноос	Ц.Баярсайхан Ц.Улаан
<p>197 3.6.5</p>	<p>Мэдээлэл харилцааны технологи, био, нано технологийн олонлтыг өргөнөөр нэвтрүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.</p>	<p>2005 оноос</p>	<p>С.Баярцогт П.Цэцээн</p>
<p>198 3.6.6</p>	<p>Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх олон улсын онгоцны тоог нэмэгдүүлэх, олон улсын томоохон нисэх буудал шинээр барихыг дэмжинэ.</p>	<p>2005-2008</p>	<p>Г.Батхүү</p>
<p>199 3.6.7</p>	<p>Агаарын тээрийн номлолт үйлчилгээ нэхэх асуудлыг судалж хэрэгжүүлнэ.</p>	<p>2005-2006</p>	<p>Г.Батхүү</p>
<p>200 3.7.1</p>	<p>3.7. Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн шинэ чадавхийг бий болгох зорилгоор аялал жуулчлалын болон мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийг шинэ шатанд гаргана. Энэ зорилтын хүрээнд:</p>	<p>2005-2008</p>	<p>Г.Батхүү</p>
	<p>1. "Электрон Монгол" хөтөлбөрийг боловсруулж баталж хэрэгжүүлж эхэлнэ.</p>	<p>2005-2008</p>	<p>С.Баярцогт</p>

		2. "Электрон засаг" дэд хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батална.	2005	С.Баярцогт
201	Цахим засаглалыг нэвтрүүлснээр төрөөс иргэд, байгууллагад үйлчлэх үйлчилгээг шинэ шатанд гаргах, иргэдээс төр, засаг уруу хандах мэдээллийн шинэ урсгалыг бий болгоно.	1. "Электрон засаг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний ихэнх хувийг хүчд сурталгүй, цаг хугацаа харгалзахгүй иргэдэд хүргэх зорилтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. 2. Төрийн мэдээллийг иргэд, хувийн хэвшилд хүргэж, нэвтрүүлж, болгох асуудлыг үе шаттай хэрэгжүүлнэ. 3. Хуулийн этгээд, байгууллагын домойн хавь, электрон шуудангийн хавьтай болгоно.	2005 оноос 2005-2008 2005 оноос	С.Баярцогт С.Баярцогт С.Баярцогт С.Баярцогт
202	Улс орны хэмжээнд нэгдмэл кодчилолыг бий болгооноор мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлнэ.	1. Гудамжны нэр, хаягуудын асуудлыг хот, аймгийн төвүүдийн хүрээнд шийдвэрлэснээр нэгдмэл кодчилал, регистр бий болгох асуудлыг үе шаттайгаар улсын хэмжээнд хэрэгжүүлнэ.	2005 оноос	С.Баярцогт Аймаг, нийслэлийн Засаг дарга
203	Цахилгаан холбооны суурь сүлжээг шинэчлэн олон улсын өргөн зурвасын сүлжээнд нэгдэнэ.	1. Төмөр замын шилэн кабелийг Орос, Хятадаар дамжин өнгөрч байгаа олон улсын урсгалд холбох асуудлыг судална. 2. Улс, хот хоорондын цахилгаан холбооны суурь сүлжээг өргөтгөн шинэчилнэ.	2005 2005 оноос	Г.Батхүү С.Баярцогт С.Баярцогт
204	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хууль, эрх зүйн орчинг боловсруулна.	1. Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын тухай багц хуулийн төслийг боловсруулна.	2005	С.Баярцогт
205	Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй, хүн ам төвлөрсөн газрын сургууль, айл өрхийг компьютержүүлж, интернэтийн үйлчилгээний хүрээ, хүргэж, өргөжүүлнэ.	1. "Бүх нийтийн компьютержүүлэлт" хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батална. 2. Тосон ялгааг (digital divide) бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн иргэд бүрт төр, бизнесийн үйлчилгээг эрх тэгш, хялбар, шуурхай байдалаар хүргэх нөхцөлийг бүрдүүлж эхэлнэ.	2005 оноос 2005-2008	С.Баярцогт С.Баярцогт
206	Төвийн болон саярагдах эрчим хүчид холбогдсон аялагдмал сумын төв, суурин газрын мэдээлэл холбооны сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	3. Интернетийн үнийг бууруулах, үйлчилгээний хүрээг өргөжүүлж, технологийн шинэчлэлт хийж эрх зүйн болон зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авна.	2005 оноос	С.Баярцогт
207	Програм хангамжийн эрэлтийг нэмэгдүүлэх замаар бүтээгдэхүүний	1. Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалтай үйлдүүлэн аялагдсан сум, суурин газруудад мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжийн технологийн шинэчлэлт хийж замаар хүн амыг мэдээлэл, холбооны олон төрлөт үйлчилгээг хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. 2. Шилэн кабелид холбогдсон аймгийн сумдыг интернетэд холбох арга хэмжээ авч, статистикийн мэдээллийг сүлжээгээр авах технологийг шилжүүлнэ.	2005 оноос 2006-2008	С.Баярцогт П.Бямбацэцэн С.Баярцогт

	өсөлтийг дэмжнэ.			
208	3.7.9	Томохон суурин газруудын автомат телефон станц <span>д</span> тоон төхнөлд үе шаттай шилжүүлнэ. Улсын хэмээнд 100 хүнд ноогдох суурин болон хөдөлгөөнт телефон хэрэглэгчдийн тоог 2008 онд дунджаар 21-д хүргэнэ.	Хангамжийн зах зээлийг хөгжүүлэхэд программ хангамжийн зохиолцагч, төслүүдийг дотоодын компаниудаар гүйцэтгүүлэх бодлогыг түлхүү баримтална.  1. Суурийн үеийн мэдээлэл, холбооны технологийн давуу талуудыг нэвтрүүлэх, улсгүй холбооны технологийг түлхүү ашиглаж замаар улсын хэмээнд 100 хүнд ноогдох суурин, хөдөлгөөнт телефон хэрэглэгчдийн тоог 2008 онд дунджаар 21-д хүргэж, интернэтийн сүлжээ, түүний хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	2005 оноос  С.Баярцогт
209	3.7.10	Интернет худалдаа, үйлчилгээ, зайны сургалт, цахим нийтлэл, зайны оношлогоог эрчимтэй нэвтрүүлнэ.	1. Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн иргэд интернетээр цахим-бизнес форумд оролцох, улмаар электрон арилжаа хийх боломжийг бүрдүүлнэ.  2. Статистийн үндэсний мэдээллийн сан болон сар, улирал, жил тутам гаргадаг статистийн боллоотын, танилцуулга, статистийн амтгалайг цахим хэлбэрээр гадаад, дотоодын хэрэглэгчдэд интернетээр хүргэх үйлчилгээг нэвтрүүлнэ.  3. Бөөний худалдааны сүлжээний мэдээллийн сүлжээг өргөтгөх, боловсрууныг болгох замаар бөөний худалдааг сүлжээгээр гүйцэтгэх үйл ажиллагаанд дэмжлэг гзүүлнэ.	2008 оноос  2006  2005-2007  С.Баярцогт  П.Бямбырзан С.Баярцогт  С.Батболд
210	3.7.11	Телевизийн өрсөн нэвтрүүлгийг тоон төхнөлд шилжүүлснээр телевизийн олон сүлгийг орон даяар хүлээн авах боломжийг бүрдүүлнэ.	1. Телевизийн нэвтрүүлэг дамжуулах сүлгийг тоон төхнөлд шилжүүлж телевизийн олон сүлгийг орон даяар хүлээн авах төхнөлийн боломжийг бүрдүүлнэ.  2. Улс орон даяар нэвтрүүлэх боловсролын, ялангуяа мэдрэлэл, харилцаа холбооны технологийн чиглэлийн боловсрол олгох радио, телевизийн нэвтрүүллийн цагийг бий болгоно.	2005 оноос  2006  С.Баярцогт Н.Алтанхуяг  П.Цагаан
211	3.7.12	Гудамж, талбай, албан байгууллага, айл өрх бүрийг хаяжуулж, шуудангийн бүсийн татгалцоонд шилжүүлнэ.	1. Манай улсад одоо хэрэглэж байгаа шуудангийн кодыг улсын хэмээний бусад төрлийн ирдэс, юдуудтай харьцуулсан судалгаа хийж, тохирсон хувилбарыг сонгон хэрэглүүлж эхэлнэ.  2. Газрын байршлын нэгдсэн кодтой үндүлээн хувийн болон нийтийн орон сууцанд шуудангийн хайрцгийг байрлуулах стандартыг боловсруулна.  3. Шуудангийн бүсчлэсэн зохион байгуулалтын талаар судалгаа хийж, бүсийн тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээ авна.	2005  2005-2008  2005-2008  Г.Батхүү С.Баярцогт  Н.Батбаяр Г.Батхүү  Г.Батхүү Аймаг, нийслэлийн Засаг дарга Г.Батхүү
212	3.7.13	Бүх шатны шуудан хүргэлтийн тогтолцоог боловсрууны болгож, шуудангийн зах зээлийн өрсөлдөөний зохицуулалтын механизмыг бүрдүүлэн шууданд санхүүгийн болон электрон худалдааны үйлчилгээг нэвтрүүлнэ.	1. Бүх шатны шуудан хүргэлтийн чөлгөл, маршрутын судалгаа хийж, оночтой тогтоох санал боловсруулж хэрэгжүүлнэ.  2. Шуудангийн зах зээлийн өрсөлдөөнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах талаар Шуудангийн тусай болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.  3. Шуудангаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэх болтгайг ханган үе шатгаар нэвтрүүлэх арга хэмжээ авна.	2005-2006  2005-2006  2005-2008  Г.Батхүү  Г.Батхүү

		<p>4. Шуудангаар электрон хуудасны худалдааны үйлчилгээ үзүүлэх бэлтгэлийг хангах үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх арга хэмжээ авна.</p> <p>5. Шуудангийн үйлчилгээний авто машины парк шинэчлэлийг урсгалжуулж, бүртгэл, кешалтын системийг нэвтрүүлж эхэлнэ.</p>	<p>2006-2008</p> <p>2005</p>	<p>Г.Батхүү</p> <p>С.Батболд</p> <p>Г.Батхүү</p>
213	3.7.14	<p>Үндэсний соёл, түүх, нийгмэлчдийн амьдралын хэв маягийг тусгасан, жуулчдыг олноор татах төслүүдийг нэрхэтэй дамжинэ.</p>	<p>2005-2007</p>	Г.Батхүү
214	3.7.15	<p>Олон улсын түвшинд нийцсэн аялал жуулчлалын цогцолборуд бий болгохыг хөгжүүлэн дамжинэ. Эдгээр цогцолборт зөвхөн шаардлагатай үйлчилгээний төрөл зүйлийг нэвтрүүлж, дэд бүтцийн барилга байгууламжийг барих, тоног төхөөрөмжийг нийлүүлэх аялгад дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулна.</p>	<p>2005-2008</p> <p>2005-2007</p> <p>2005-2008</p> <p>2006-2007</p> <p>2005-2008</p>	<p>Г.Батхүү</p> <p>Г.Батхүү</p> <p>Г.Батхүү</p> <p>Г.Батхүү</p> <p>Г.Батхүү</p>
215	3.7.16	<p>Жуулчдын хүлээн авах байр, жуулчны бааз, жуулчдад зориулсан үйлчилгээнд тодорхой стандартаг гаргах мөрдүүлнэ.</p>	2005-2006	Г.Батхүү
216	3.7.17	<p>Аймаг, хот, төвлөрсөн газруудыг аялал жуулчлал хөгжүүлэх тусгай хөтөлбөр, төлөвлөгөө, бүтэцтэй болгоно.</p>	<p>2005-2008</p> <p>2006-2008</p>	<p>Г.Батхүү</p> <p>Аймаг, нийслэлийн Засаг дарга</p>
217	3.7.18	<p>Аялал, жуулчлалын бүс нутгийн зам, гүүрийг тавих, тэмдэжүүлэх ажлыг хийнэ.</p>	<p>2005-2007</p> <p>2006-2008</p>	<p>Г.Батхүү</p> <p>Г.Батхүү</p>
218	3.7.19	<p>Жуулчдыг хүлээн авах зочид буудлуудын зорилгоийг дээшлүүлж, хүчин чадлыг эрс нэмэгдүүлнэ.</p>	<p>2005-2008</p> <p>2005-2008</p>	<p>Г.Батхүү</p> <p>Нийслэлийн Засаг дарга</p> <p>Г.Батхүү</p>

219	3.7.20	<p>Дотоодын жуулчлалыг идэвхтэй хөгжүүлэх, салбарын үйл ажиллагааны улирлын шинэ чандрыг байгасана.</p>	<p>1. Жуулчдыг зохион байгуулалтайгаар орон нутагт аялуулах хотөлбөр боловсруулна.</p> <p>2. Цэцэн бааз, өвлийн улиралд ажиллах жуулчны бааз шинээр байгуулна.</p> <p>3. Өвлийн улиралд зохион байгуулдаг уламжлалт арга хэмжээнүүдийг зохион байгуулахад тусалцаа үзүүлнэ.</p> <p>4. Хархорин-Хужирт-Найман нуур бус нутагт гадаад, дотоодын жуулчлалыг хөгжүүлэх шинэ маршрулын замыг засварлан, тэмдэжүүлэх ажлыг хийнэ.</p>	<p>2006-2008</p> <p>2006-2008</p> <p>2005-2008</p> <p>2005-2008</p>	<p>Г.Батхүү Аймаг нийслэлийн Засаг дарга</p> <p>Г.Батхүү Нийслэлийн Засаг дарга</p> <p>Г.Батхүү Аймаг нийслэлийн Засаг дарга</p> <p>Г.Батхүү</p>
220	3.7.21	<p>Жуулчдыг татах зорилгоор ивээн хябарчилсан системийг нэвтрүүлэх асуудлыг хэлбэлдэх орнуудтай хамтран судалж хэрэгжүүлнэ.</p>	<p>1. Аялал жуулчлалын зах зээлийн орнуудын жуулчдад ивээн хябарилт үзүүлэх асуудлыг судалж дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>2005-2008</p>	<p>Г.Батхүү Ц.Мөнх-Орип</p>
221	3.7.22	<p>Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг Монгол Түмний түүх, уламжлалыг сэргээх аялал жуулчлалын орон, дэд бүтцийг хөгжүүлэх бодолготой уялдуулан зохион байгуулна.</p>	<p>1. Монгол оронг дэлхийн аялал жуулчлалын санхээртэй бус нутаг болгон хөгжүүлэхэд чиглэсэн гадаад сурталчилгааг нэмэгдүүлнэ.</p> <p>2. Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх маршрутын дагуух зам, гүүрний засах, тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.</p>	<p>2005-2008</p> <p>2005-2006</p>	<p>Г.Батхүү</p> <p>Г.Батхүү</p>
222	3.7.23	<p>Улиастай-Улаангом-Мерен чиглэлийн тоон сүлжээг байгуулна.</p>	<p>1. Хот хороондыг сүлжээний найдвартай ажиллагааг хангааны тулд STM-1 буюу түгээс дээш хурдыг илгэн кабелийн сүлжээг байгуулж асана.</p>	<p>2005 оноос</p>	<p>С.Баярцогт</p>
223	3.7.24	<p>Улаанбаатар-Дашинчолон-Булган, Дашинчолон-Аравхаар чиглэлийн дамжуулах сүлжээг илгэн кабелиер шансчилж, Налайх-Багануурын дамжуулах сүлжээг өргөтгөнө.</p>	<p>1. Улаанбаатар-Дашинчолон чиглэлийн илгэн кабелийн сүлжээг дуусган, цаашид өндөр хурдыг дамжуулах байгууламжийг судалгааны ажлыг хийж, хамгийн оновчтой хувилбарыг сонгон хэрэгжүүлж эхэлнэ.</p> <p>2. Налайх-Багануур чиглэлийн дамжуулах сүлжээг өргөтгөнө.</p>	<p>2005</p> <p>2005 оноос</p>	<p>С.Баярцогт</p> <p>С.Баярцогт</p>
224	3.7.25	<p>Хотын захын гэр хороолол, дагуул хотуудыг холбоожуулж, ингернэцийн сүлжээг өргөтгөнө.</p>	<p>1. Мэлчид, хөдөөгийн хөдөлмөрчдэд мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хурхаж арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	<p>2007 оноос</p>	<p>С.Баярцогт</p>
<b>3.8. Экспортын өрсөвлөл бүтцийг өөрчлөхөд чиглэсэн гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:</b>					
225	3.8.1	<p>Экспортыг бүх талаар дэмжих, түүнд зээлэг байгаа ашигт малтмалын хэмжээг бууруулахгүйсгэр, экспортын төлөржилтийг нэмэгдүүлнэ. Экспортлох гаргах шинэ бүтээгдэхүүнийг дэмжнэ.</p>	<p>1. Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийн хүрээнд Монголын ноолуур, ноолуурын бүтээгдэхүүнийг газар зүйн заалттай болгох талаар судалгаа хэрэгжүүлнэ.</p> <p>2. Экспортлох гаргах болох шинэ бүтээгдэхүүний үзэсгэлэн зохион байгуулна, гадаад зах зээлийн мэдээллээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Экспортыг дэмжих төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ авна.</p>	<p>2005-2008</p> <p>2005-2008</p>	<p>С.Батболд</p> <p>С.Батболд</p>



233	3.6.9	Зүүн, Зүүн өмнөд болон Зүүн хойд Ази, Европын орнуудтай бизнесийн харилцааг хөгжүүлэхэд ачаар, Монгол Улсын эрх зүйн орчин, Монголын компани, монгол брэндүүдийг сурталчлах зорилгоор цахим-бизнес форум ажиллуулна.	1. Цахим бизнес форум байгуулах асуудлаар төсөл боловсруулж, гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ авна. 2. Зүүн хойд Ази, АСЕАН, АТЕК-ийн орнууд, Төв азийн орнууд болон худалдаа зөрийн засгийн томоохон түш орнуудтай худалдааг өргөвүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих талаар амжилтаж, бизнес уулзалтуудыг зохион байгуулна.	2005 2005-2008	С.Батболд С.Батболд Ц.Мөнх-ориг
234	3.6.10	Бүтээгдэхүүний стандартыг сайжруулснаар ОХУ, БНХАУ болон бусад зах зээлтэй худалдааны хэлцдэрээр хүлээсэн үүргийн дагуу Монгол Улсын стандартыг бүрэн хүлээн зөвшөөрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.	1. Үндэрсний стандартын түвшинг дээшлүүлэх, олон улс, бус нутаг, гадаад орны дэвшилт стандартыг авч хэрэглэх, бүтээгдэхүүний чанар, стандартын талаар байгуулсан хэлцдэрснийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авна. 2. Бүтээгдэхүүний чанар, стандартын талаар байгуулсан хэлцдэрсийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.	2005-2008	С.Батболд
235	3.6.11	Хөгжөөлтийн ерөнхий зарчимд бараа, бүтээгдэхүүн нэмж оруулах талаар Европын Холбоо, АНУ, Япон болон бусад оронтой хийх хэлцлийг идэвхжүүлнэ.	1. Европын холбоо, АНУ, Япон болон бусад худалдааны гол түншүүдтэй Хөгжөөлтийн ерөнхий системд Монголын барааг нэмж камруулах, худалдааг хөгвөө-лэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2005-2008	С.Батболд Ц.Мөнх-Ориг
<b>Доргов. ХОТ БАЙГУУЛАЛТ, БУС НУТАГ, ХӨДӨВГИЙН БОДЛОГО</b>					
<b>4.1. Түүх, соёл, байгаль орчин, эдийн засгийн онцлогийг харгалзан хот төлөвлөлт, байгуулалт, барилга, газар зохион байгуулалтад шинэтгэл хийж, оршин суугчдынх нь эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. Энэ зорилгын хүрээнд:</b>					
236	4.1.1	Хот төлөвлөлтийн аргачлал, стандартыг олон улсын түвшинд хүргэж хот байгуулалтын тогтолцоог шинэчлэх ажлыг эхлүүлнэ.	1. Канад, Солонгос, ОХУ, Герман, Япон зэрэг орнуудын хот байгуулалтын асуудлыг судалж, холбогдох баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, Хот байгуулалтын тухай жууль зөвх өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна. 2. Тогтвортой хотын үзэл баримтлалын хүрээнд гадаад орнуудын туршлалыг судлан хэрэгжүүлж, дүрээг харгалзан шинэ төсүүдийг байгуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	2005-2007 2005-2007	Н.Батбаяр Н.Батбаяр
237	4.1.2	"Дачин манган орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1. "Дачин манган орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх жууль зөх зүй, санхүү, татвар, бизнесийн талаар орчинг бүрдүүлж, газрын харилцаа, хот байгуулалтын өнөөтэй бодлогыг тодорхойлон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. 2. Төрийн амилтан, албан хаагчдын орон сууцны дэд хөтөлбөр боловсруулж төрийн төв байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	2005-2008	Н.Батбаяр Н.Алтанхууг С.Батболд А.Мяг Аймаг Нийслэлийн Засаг дарга Н.Батбаяр Сайд нар
238	4.1.3	Эртний нийслэл Хархоринг жишээг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1. Хархорин хотыг жишээг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, хотын засагчдын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	2005-2008	Н.Батбаяр Н.Алтанхууг
239	4.1.4	Хот, суурин газруудын авто зам, гудамж талбайн тохиолтод иргэдийн аюулгүй байдлыг хангах стандартыг тогтоож мөрдүүлнэ.	1. Хот байгуулалт, барилгын норм, дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ. 2. Хот, суурин газрын зам талбайн засвар, аргачлалтын норм, дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.	2005-2007 2005-2007	Н.Батбаяр Г.Батхүү

		3. Хотын замын төлөвлөлтийн норм, дүрмийг шинээр боловсруулан мөрдүүлнэ.	2005-2007	Г.Батхүү
240 4.1.5	Хүн амын нягтрал, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний төвлөрөлд нийцүүлэн засаг захиргааны шиксэлтийн болон хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.	1. Улсын хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв-хошуудын зорилтот хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд Тулхуу хуваарилах арга, мөшүүргийг судлан тогтоож, хэрэгжүүлж эзлэнэ. 2. Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн стратегийг үндэслэн Бүсүүдийн эрчим хүч, зам тээвэр, модорзот хөтөлбөний хангамжийн сүлжээг үргэлжлүүлэн байгуулах зорилт арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган, гадаад орны эзэл тусламжаар дэмжин хэрэгжүүлнэ.	2006 оноос жил бүр  2006 оноос жил бүр	Н.Лопсанууг Ч.Улаан Т.Очирхүү Г.Батхүү  Н.Лопсанууг Ч.Улаан Н.Балбаар
241 4.1.6	Хот, суурингийн дулаан, цэвэр ба бохир ус, цахилгаан шугам сүлжээнд дэвшилтэт, хэмнэлттэй технологи нэвтрүүлж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах замаар өсөн нэмэгдэх хэрэгцээг хангана.	1. Хот, суурин газрын цахилгаан, дулааны шугам сүлжээнд дэвшилтэт, хэмнэлттэй технологи нэвтрүүлэн хэрэглээний өсөлтийг хангана. 2. Сэргээгдэх эрчим хүч ашиглахыг дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2005-2008  2005-2008	Т.Очирхүү  Т.Очирхүү
242 4.1.7	Хотын доторх бүсэлтийн нэрийвчлсэн жил хөдөлгөөн тогтоох, журам гаргаж мөрддөг болгох ажлыг хэвшүүлэн барилга байшинд чанар, зориулалтын ангилал тогтоож, регистрийн дугаар олгоно.	3. Хот, суурин газруудын дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний төхивийн түвшинд үнэлгээ өгч, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ. 4. Хэмнэлттэй технологи нэвтрүүлж, нэмэгдэх хэрэгцээг хангах асуудлыг орон нутгийн үндэслэлэн үйл ажиллагааны хөтөлбөрт тусуулж хэрэгжүүлнэ.	2005-2007  2005-2007	Н.Балбаар  Н.Балбаар
243 4.1.8	Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, замын сүлжээх тойргийн горимд оруулж, гол урсгалуудыг нэг чиглэлтэй болгох арга хэмжээ авна.	1. Хот суурин газрын төлөвлөлтийн өнөөгийн байдалд үнэлэлт, дүнлэлт өгч, хотын дотоод бүсчлэлийн хилийг нарийвчлан тогтоож мөрдүүлэн хот байгуулалтын цэгцтэй бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. 2. Хот суурингийн газрын кадастрын хүрээнд барилга байшинд чанар, зориулалтын ангилал тогтоож, регистрийн дугаар олгож хотын кадастрын ажлыг эхлүүлнэ.	2005-2008  2005-2008	Н.Балбаар Нийслэлийн Засаг дарга  Н.Балбаар Нийслэлийн Засаг дарга
		1. Улаанбаатар хотын авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг судалгааг хийж авто замын хөдөлгөөний өмнөхөөнийг сайжруулж зарим чиглэлийн замуудыг тойргийн горимд оруулж урсгалыг нэг чиглэлийн хөдөлгөөнтэй болгох техник зөвлөн засгийн үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлнэ. 2. Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатгал, түгжрэлгүй байлгах хангалтын болон зохицуулалтын арга хэмжээ авна. 3. Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношлогооны төмүүрийн үйл ажиллагааг жигдрүүлж хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.	2005-2008  2005-2008  2005	Г.Батхүү Н.Балбаар  Г.Батхүү Ц.Нямдорж Нийслэлийн Засаг дарга Г.Батхүү Алмэг, нийслэлийн Засаг дарга

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005 оны 3 дугаар сарын 14-ны өдөр

Дугаар 2/01

Улаанбаатар хот

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим  
11.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Цэцийн гишүүн Д.Наранчимэг /илтгэгч/, Ж.Болдбаатар, Н.Жанцан, Ч.Дашням нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Өргөдөл гаргагч Сонгинохайрхан дүүргийн 16 дугаар хороо, 25 дугаар байрны 31 тоотод оршин суугч иргэн П.Баттогтох гадаадад суралцахаар явсан тул өөрийн биеэр оролцоогүй ба итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулалгүй өөрийг нь байлцуулалгүй хуралдаан хуралдуулж шийдвэр гаргахыг зөвшөөрсөн. Харин Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн хуралдаанд оролцлоо.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: "Шүүгчдийн зөвлөлгөөнийг Ерөнхий шүүгч удирдана. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ. Шүүгчдийн зөвлөлгөөн тухайн шүүхийн шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон тохиолдолд хүчинтэй байна. Шүүгч бүр тэгш эрхтэй оролцоно" гэж заасан байдаг. Энэ хэсгийн "... Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ..." гэсэн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Ардчилсан ёс... төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалт болон Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг урьдчилан шалгаж Цэцийн гишүүний 2005 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 5/03 дугаар тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэв.

Иргэн П.Баттогтох өргөдөлдөө: "Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэж заасан байдаг.

Үндсэн хуульд заагдсан "хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх" зарчим бол тухайн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх явдлыг ойлгодог билээ.

Энэ ойлголтыг баталгаажуулж Шүүхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргана" гэж тусгасан.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасан байдаг бөгөөд "ардчилсан ёс" гэсэн ойлголт нь "аливаа асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх" гэсэн ухагдахууныг өөртөө агуулдаг билээ. Шүүх байгууллага бол төрийг төлөөлж, төрийн нэрийн өмнөөс ард түмэнд үйлчилж байдаг байгууллагуудын нэг тул түүний үйл ажиллагаанд "ардчилсан ёсны зарчим буюу асуудлыг олонхиор шийдвэрлэх" зарчим үйлчлэх ёстой. Энэ нь шүүх хэрэг, маргааныг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үед тод илрэх учиртай.

Гэтэл 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: "Шүүгчдийн зөвлөлгөөнийг Ерөнхий шүүгч удирдана. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ. Шүүгчдийн зөвлөлгөөн тухайн шүүхийн шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон тохиолдолд хүчинтэй байна. Шүүгч бүр тэгш эрхтэй оролцоно" гэж заасан байдаг бөгөөд дээрхи заалтын "...Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ..." гэсэн нь Үндсэн хуулийн дээр дурдсан Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалт, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх заалт тус бүрийг зөрчиж байна.

Тодруулбал, тухайн шатны шүүгчдийн зөвлөлгөөний бүрэлдэхүүн тэгш тоотой хуралдаж байх үед энэ заалт хамарах бөгөөд шүүгчдийн санал тэнцвэл буюу 50х50 хувийн харьцаатай болвол ерөнхий шүүгч нь аль талд орсон байна, уг талын гаргасан санал нь шийдвэр болж хувирах боломжтой байна. Энэ нь шүүх аливаа асуудлыг олонхийн саналаар буюу 51х49 хувийн харьцаатайгаар шийдвэрлэх ёстой гэсэн Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудыг сууд зөрчсөн заалт болжээ.

Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3

дахь хэсгийн "...Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ..." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тул уг заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргаж, улмаар хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

Тэрээр өргөдөлдөө жич дурьдахдаа: "Энэ өргөдөлтэй агуулга ижил өргөдлийг миний бие 2004 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гарган, улмаар Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 2/01 дугаар дүгнэлт гарч, миний өргөдлийг хангаж шийдвэрлэсэн бөгөөд Цэцийн уг дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр хууль гаргаж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж Цэцээс дүгнэгдсэн/ хүчингүй болгосон билээ... гэсэн байна.

Иргэн П.Баттогтох 2005 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд нэмэлт тайлбар гаргахдаа: "...Миний бие Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өөрийн биеэр оролцож чадахгүй болсон тул дараах тайлбарыг гаргаж байна.Үүнд: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар шүүгчдийн зөвлөлгөөнөөр хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тодорхой хугацаагаар хуваарь гаргаж томилох /70 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг 30 хүртэл хоноогоор сунгах /71 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/, Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол уг асуудлыг шийдвэрлэх /92 дугаар зүйлийн 6 дахь хэсэг/ зэрэг эрх хэмжээтэй билээ.

Нотлох баримт нэмж бүрдүүлэх шаардлагатай үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгах, Ерөнхий шүүгч хэргийг дангаар хянан шийдвэрлэхдээ тухайн хэрэгт хувийн сонирхол байна гэж үзвэл түүнийг хянан шийдвэрлэх зэрэг эрх хэмжээг шүүгчдийн зөвлөлгөөн эдэлж байгаагаараа тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд өөрийн зүгээс нөлөөлж, хувь нэмрээ оруулж, оролцох байдаг онцлогтой билээ.

Ийм учраас Үндсэн хуульд заасан "Шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан шийдвэрлэнэ" гэсэн заалт шүүгчдийн зөвлөлгөөнд хатуу мөрдөгдөх ёстой бөгөөд хэлэлцэх асуудлаа шүүгчдийн зөвлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэх учиртай билээ.

Түүнчлэн Үндсэн хуульд "Ардчилсан ёс, ...бол төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалт нь төрийн байгууллагад, тэр тусмаа шударга үнэнийг тогтоогч шүүх байгууллагад тод томруунаар илрэх учиртай. Өөрөөр хэлбэл, төрийн

байгууллагад аливаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэж л байгаа юм бол олонхийн саналаар л шийдвэрээ батлах ёстой. Хэрэв тэнцүү саналын аль нэгээр нь шийдвэрийг баталж байх юм бол санал хураалт явуулах шаардлагагүй, утгагүй болно.

"Ардчилсан ёс" гэдэг бол олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэхийг ойлгох бөгөөд шүүгчдийн зөвлөлгөөнд "Ардчилсан ёс" мөрдөгдөх ёстой гэдгийг Үндсэн хууль бидэнд сануулсаар байна. Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ" гэсэн заалтыг хүчингүй болгож өгнө үү..." гэжээ.

*Энэхүү маргааны хариуцагч тал болох Улсын Их Хурлыг төлөөлж Монгол Улсын Их Хурлын даргын 2005 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 37 дугаар захирамжаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:*

"1.Иргэн П.Баттогтох өргөдөлдөө Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ" гэсэн заалт нь бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэхээр заасан Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэжээ.

Шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаан дахь ардчилсан ёсны зарчмыг улам бүр гүнзгийрүүлэх үүднээс Улсын Их Хурлаас 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлд Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчдийн зөвлөлгөөн ажиллахаар хуульчилсан билээ. Шүүгчдийн зөвлөлгөөнийг жилд 2-оос доошгүй удаа хийлгэнэ. Шүүгчдийн зөвлөлгөөн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаан даргалагчийг томилох хуваарийг тогтоох, түр эгзүй шүүгчийн ажлыг хуваарилах, шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн сонгогчдын нэрсийн жагсаалтаас сонгон авах журам тогтоох, тухайн шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх зэрэг тухайн шүүхтэй холбогдсон дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй юм. Шүүгчдийн зөвлөлгөөнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч товлон зарлаж, удирдан хуралдуулж байхаар заажээ.

Улмаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн дагуу тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох асуудлыг тодруулан зохицуулсан юм.

Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэхээр заасан Үндсэн хуулийн энэхүү зарчим нь иргэнээс гаргасан нэхэмжлэлийг шүүхэд хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахаас биш тухайн шүүхээс дотоод зохион байгуулалтын асуудлаа хэрэгжүүлдэг шүүгчдийн зөвлөлгөөний үйл ажиллагаанд холбогдолгүй гэж үзэж байна.

2.Өргөдөл гаргагч өргөдөлдөө шүүх байгууллага бол төрийг төлөөлж, төрийн нэрийн өмнөөс ард түмэнд үйлчилж байдаг байгууллагуудын нэг тул түүний үйл ажиллагаанд "ардчилсан ёсны зарчим буюу асуудлыг олонхиор шийдвэрлэх" зарчим үйлчлэх ёстой. Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээр дурдсан заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчжээ гэжээ. Мөн өргөдөл гаргагч цааш нь энэ зарчим нь шүүх хэрэг, маргааныг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үед тод илрэх учиртай гэж бичсэн байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн "Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ" гэсэн заалт нь шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдолгүй учраас Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй байна.

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-нд баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэний нэхэмжлэлийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч хуваарилдаг байсан өмнөх зарчмыг үндсээр нь өөрчилж шүүгч бүрт урьдчилсан байдлаар тухайн жил, хагас жилд тус шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс хуваарилж байхаар тогтоосон юм. Ингэснээр хэрэг шийдвэрлэхэд аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг хааж, шүүгчийн хараат тус байх зарчим буюу Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлсэн гэж үзэж байна..." гэжээ.

**ҮНДЭСЛЭЛ:**

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: "Шүүгчдийн зөвлөлгөөнийг Ерөнхий шүүгч удирдана. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар

шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ..." гэжээ.

Дээрх заалт нь: 1.Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн нь шүүхээс хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг тусгасан байна. Шүүгчдийн зөвлөлгөөнийг шүүхийн дотоод зохион байгуулалтын ажлыг зохицуулахаар хуульчилсан байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

**ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалт, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 15 хоногт багтаан энэхүү дүгнэлтийг хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГА****Ж.БЯМБАДОРЖ****ГИШҮҮД****Ж.БОЛДБААТАР  
Н.ЖАНЦАН  
Ч.ДАШНЯМ  
Д.НАРАНЧИМЭГ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12,

Төрийн ордон

☎ 329612

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 5